




“ИНВЕСКОР ЭЙ БИ ЭС ТЗК” ХХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК
(Хөрөнгө итгэмжлэн удирдагч)
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/,
Олимпийн гудамж, 7/2 байр, 803 тоот
Утас: +976-70122346

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Д.Баясгалан

/“Инвескор Эй Би Эс ТЗК” ХХК-ийн ТУЗ-ийн дарга/



Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл	6

1. ХБҮЦ-ны мэдээлэл

"Инвескор Эй Би Эс ТЗК" ХХК нь 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Инвескор ББСБ" ХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Инвескор Эй Би Эс ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Д.Баясгалан, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Г.Санжаасүрэн, А.Хэрлэнчимэг нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК ажиллаж байна.

"Инвескор Эй Би Эс ТЗК" ХХК нь 2024 оны 8 дугаар сарын 02-ны өдөр 50.0 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын 05-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Инвескор Эй Би Эс ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011863043
Регистрийн дугаар	7008721
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2024/08/02
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	384
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	500,000
ХБҮЦ (сая төг.)	50,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	17.0%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь 2024 онд ХБҮЦ-ны хүүгийн төлбөрт 2.12 тэрбум төгрөгийг хуваарийн дагуу төлсөн бөгөөд үндсэн төлбөрийг төлж эхлээгүй байна. ХБҮЦ-ны үлдэгдэл хугацаанд Хүснэгт 2-т харуулсан төлбөрийг төлнө.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үлдэгдэл
1	2025/03/06	-	2,119,178,082.19	50,000,000,000.00
2	2025/06/05	-	2,119,178,082.19	50,000,000,000.00
3	2025/09/05	25,000,000,000.00	2,142,465,753.42	25,000,000,000.00
4	2025/12/05	-	1,059,589,041.10	25,000,000,000.00
5	2026/03/05	25,000,000,000.00	1,047,945,205.48	-
Нийт		50,000,000,000.00	8,488,356,164.38	-

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш тайлант хугацааны байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 7.12 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2024.09.05	2024.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	49,981,757,007.93	46,422,654,539.52	-7.12%
Зээлийн дундаж үлдэгдэл	138,838,213.91	142,838,937.04	2.88%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	1.54%	3.28%	1.75%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	10.30%	15.30%	5.00%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	33.60%	33.49%	-0.12%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	54.79%	52.64%	-2.15%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	9.48	12.45	31.37%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	31.91	28.36	-11.14%
Сарын дундаж төлбөрийн дүн	7,700,029.38	8,711,395.85	13.13%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	16,073,285.69	22,287,789.76	38.66%
Зээлийн тоо /нийт/	360	325	-9.72%
Иргэн	332	298	-10.24%
Хуулийн этгээд	28	27	-3.57%
Барьцаа хөрөнгийн төрөл	Автотээврийн хэрэгсэл		-
Барьцаа хөрөнгийн үнэлгээ	101,987,504,300	101,045,344,800	-0.92%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	0.00%	-
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт (өсөн нэмэгдсэн дүнгээр)	-	15,892,643,639.38*	
Зээлийн үндсэн төлбөр	-	10,884,150,522.82	
Хүүгийн төлбөр	-	5,003,576,335.38	
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	-	4,916,781.17	

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2024 оны 12 дугаар сарын эргэн төлөлт болох 3.52 тэрбум төгрөгийг гэрээний дагуу 2025 оны 01 дүгээр сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Инвескор Эй Би Эс ТЗК" ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ХБҮЦ-ны төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 670.0 сая төгрөг, хадгаламжийн хүү 6.5 хувь, харилцах дансны үлдэгдэл 34.96 сая төгрөг байна.

Тайлант хугацаанд "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь "Инвескор Эй Би Эс ТЗК" ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам"-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	47	-
2	Гэрээний дагуу буцаан шилжүүлсэн	14	2,056,672,593.22
3	Багцад нэмж бүртгэсэн	26	9,381,720,650.46
Нийт		87	11,438,393,243.68

3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Инвескор Эй Би Эс ТЗК” ХХК-ийг “Инвескор ББСБ” ХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Инвескор ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч”) байна.

2024 оны 4 дугаар сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 02 тоот шийдвэрээр Д.Баясгалан, Г.Санжаасүрэн, А.Хэрлэнчимэг нарыг ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар ердийн гишүүн Д.Баясгаланг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 3 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2024.05.02	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох тухай Журам батлах тухай	Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ердийн гишүүн Д.Баясгаланг томилов. “Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам”-ыг батлав.
2	2024.06.18	ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга томилох тухай Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай ХБҮЦ гаргахтай холбоотой оролцогч талууд сонгох, холбогдох гэрээг батлах тухай Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл олгох тухай Бодлогын баримт бичиг батлах тухай	ТУЗ-ийн Нарийн бичгийн даргыг томилов. Олон нийтэд нээлттэй санал болгон ХБҮЦ гаргах аргаар шийдвэрлэж, ХБҮЦ-ны ерөнхий нөхцөл болон хөрөнгийн багцад тавигдах шалгуурыг батлав. Үйлчилгээ үзүүлэгчээр “Инвескор ББСБ” ХК-ийг, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК-ийг, Санхүүгийн хөндлөнгийн аудитор оор “Лидер Экаунт Аудит” ХХК-ийг, Хуулийн хөндлөнгийн шинжээч, хуулийн зөвлөхөөр “Өмгөөллийн ЭйДиЭс энд Хаанлекс” ХХН-ийг, Хөндлөнгийн санхүүгийн шинжээчээр “Си Пи Ти Эй Аудит” ХХК-ийг тус тус сонгож, холбогдох гэрээг байгуулав. Компанийн толгой компани буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй ХБҮЦ гаргах үйл ажиллагааны холбогдох гэрээнүүдийг байгуулах, холбоо хамаарал бүхий хуулийн этгээд болох “Инвескор Капитал ҮЦК” ХХК-тай Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гурван талт гэрээ байгуулахыг зөвшөөрөв. ТЗК-ийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх журмуудыг батлав.

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
3	2024.10.16	Тайлан батлах тухай	2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлэв.